

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ

2019 оны 10 дугаар сар 29

Монголбанкны Хяналтын Зөвлөл(МБХЗ) 2019 оны ажлын төлөвлөгөөний дагуу мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаарх гадаад орнуудын туршлагатай танилцаж, өөрийн орны эрх зүйн орчин, Монголбанкнаас мөнгөний бодлогын шийдвэрийн хэрэгжилтийн тайлан, мэдээ гаргалтын байдал зэрэгтэй харьцуулан, санал дүгнэлт гаргалаа. Манай орны хувьд Төв банк төгрөгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилттой, үүний хэрэгжилтийг хангахын тулд төгрөгийн ханшийн болон үнийг тогтвортой, ончтой түвшинд байлгахад Монголбанк тэргүүлэх үүрэгтэй. Энэхүү үүргийг Монголбанк мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангах хэрэгслүүдээр дамжуулан биелүүлнэ.

Нэг. Мөнгөний бодлогын хэрэгжилтийн тухай олон улсын туршлагаас.

Өндөр хөгжилтэй орнуудын төв банкуудын мөнгөний бодлогын хэрэгжилтийн тухай ойлголтоос эхлэн авч үзлээ. Тэдгээр орнуудад мөнгөний бодлогын хэрэгжилтийн үр дүн нь банкны төлбөр төлөх бэлэн эх үүсвэрийн хангалт /banks' funding liquidity/, санхүүгийн тогтвортой байдал /financial stability/, төв банкны эрсдэлийн удирдлага /central bank risk management/-ын чадавх зэргээр хэмжигддэг ажээ.

Мөнгөний бодлогын шийдвэр, үйл ажиллагааг хэвийн ба хямралын үеийн гэж ялгадаг байна. Хэвийн үеийн мөнгөний бодлогын хэрэгжилт нь уламжлалт арга ажиллагаанд голчлон түшиглэх бөгөөд мөнгөний бодлогын хэрэгслүүд ба макро эдийн засгийн харилцан уялдааг хангахад оршино.

Эдийн засаг хэвийн үед хөрөнгө мөнгөний нөөц бүрдүүлж, түүнийгээ хямралын үед ашиглах, нөгөө талаас эдийн засаг хямдралтай үед аврах шаардлагатай банкны салбар, үйлдвэрлэл, үйлчилгээг санхүүгийн эх үүсвэрээр хангах, мөнгөний бодлогын зөөлрүүлсэн арга хэрэгсэл эсвэл эсрэгээрээ тодорхой хэмжээний хязгаарлалт явуулдаг.

Санхүүгийн хямралтай үед мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь хэд хэдэн нэмэгдэл шалгуураас бүрддэг. Тухайлбал, үнийн тогтвортой байдлаас гадна ажлын байр, эдийн засгийн тэнцвэртэй өсөлт, бодит эдийн засаг (өрх, засгийн газар, компанит)-т олгох зээлийн боломж тэдгээрийн хүү зэрэг мөнгөний бодлогын нөлөөллийн механизмын ашиглалт багтдаг ажээ.

Эхний ээлжинд мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангадаг арга замыг авч үзье. Мөнгөний бодлогын хэрэгжилт нь **нэгд** мөнгөний бодлогын зорилтын хэрэгжилтийг хянах үйл ажиллагааны нэгдсэн хүрээ/дүрэм/ тогтоохоос эхэлдэг ажээ. Бодлогын хэрэгжилтийн **хоёрдахь** элемент бол арилжааны банкуудаас Төв банкуудад байршуулдаг хадгаламжийн хэсгийн хэмжээнд нөлөө үзүүлэх болон мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилтыг хангахад чиглэгдсэн нээлттэй зах зээлийн механизм, санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах явдал болно. Энэхүү хоёрдахь элементийг “ банкны ликвидитийн удирдлага” гэдэг байна. Өрнөдийн орнуудын төв банкнаас зарладаг хүү бол Төв банкнаас олгох богино хугацаат зээлийн хүү эсвэл банкны нөөц мөнгөнд тооцох хүү гэж голчлон ойлгогдож байна. Мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь дараах шинж тэмдгүүдийг агуулдаг байна. Үүнд: а/Тавигдсан зорилтыг Төв банкууд хянаж удирдах боломжтой байх ёстой, б/Мөнгөний бодлогын тэргүүлэх, тухайлбал үнийн тогтвортой байдал гэх мэт зорилтыг хангахад нөлөө үзүүлэх хэмжээний эдийн засгийн утга агуулгатай байх, в/Мөнгөний бодлогын баримжаат байр

суурьтай буюу Мөнгөний бодлогыг тодорхойлогч мэргэжлийн байгууллагын тогтоосон зорилт байх, Жишээ нь АНУ-ын Холбооны Нөөцийн дэргэдэх Холбооны Нээлттэй Зах зээлийн хороо эсвэл Европын Төв банкны Удирдах зөвлөлийн шийдвэрүүд байх учиртай. г/Төв банкны мөнгөний бодлогын хэрэгжилтийн мэргэжилтнүүдэд тэдний хийх зүйлийн талаарх гарын авлага-буюу баримжаа болохуйц байх зэрэг болно. Манай улсын мөнгөний бодлогын зорилт нь дээрх шинж тэмдэгүүдийг агуулж буй эсэхийг Монголбанкны мэргэжлийн хүмүүс тодорхойлох учиртай.

Санхүүгийн хямралтай үед мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт хэд хэдэн нэмэгдэл үзүүлэлтүүдээс бүрддэг ажээ. Тухайлбал, үнийн тогтвортой байдлаас гадна ажлын байр, эдийн засгийн тэнцвэртэй өсөлт, мөнгөний бодлогын нөлөөллийн механизм зэрэг болно. Мөнгөний бодлогын нөлөөллийн механизмын бүтцэд зээлийн хүүний ончтой төвшин, бодит эдийн засагт нийлүүлэх хөрөнгийг бүрдүүлж ашиглах зэрэг хүчин зүйлс багтана. Бодит эдийн засгийн бүрэлдэхүүн гэвэл өрх гэр, засгийн газар, пүүс компанийг нэрлэж болно.(the transmission mechanism of monetary policy, such as in particular the actual price and availability of credit to the real economy, i.e households, the state, and corporate sector).

Мөнгөний бодлогын хэрэгжилтийн хэрэгслүүдийн нэр төрөл, тэдгээрийн ашиглалтыг авч үзье.

Мөнгөний бодлогын хэрэгслүүд: Эдгээр хэрэгслүүд нь мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилтыг хангахад зориулан Төв банкнуудын хэрэглэдэг “багажууд” нэртэй хэрэгслүүд байдаг ажээ. Төв банкууд голчлон 3 арга хэрэгслүүд хэрэглэдэг агаад тэдгээрийг нэрлэвэл: а/Нээлттэй зах зээлийн ажиллагаа, б/санхүүгийн хэрэгслүүд, в/заавал байлгах нөөц.

Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа гэдэгт *Төв банкны* санаачилгаар төв банк болон арилжааны банкуудын хооронд хийгддэг гүйлгээнүүд хамаардаг байна. Тухайлбал, нэгд өрийн бичгийн худалдаа буюу актив/asset/ хөрөнгө худалдах болон худалдан авах ажиллагаа, хоёрдахь нь зээллэг. Жишээ нь аукцион эсвэл тендер зохион байгуулах замаар олгодог зээл ажээ. Дахин тодотгон хэлэхэд энэ хоёр ажиллагаа Төв банкны санаачилгаар хийгддэг нь анхаарал татаж байна. Ямар үндэслэл, шалтгаанаар санаачилга Төв банкнаас гардгийг Монголбанкны болон олон улсын экспертүүдтэй зөвлөлдөж тодруулах хэрэгтэй болно.

Санхүүгийн хэрэгслүүд: Эдгээрийг ашиглах санаачилгыг *арилжааны банкууд гаргах* бөгөөд Төв банкууд тодорхой нөхцөл хангавал хэлцэлд ордог ажээ. Санхүүгийн хэрэгслийн нэгдэх нь **хямдруулсан¹ хүүтэй зээллэг бүхий механизм.** Үүний дагуу бол арилжааны банкууд шаардлагатай үедээ богино хугацаат үнэт цаасыг төв банкуудад тэдний тогтоосон үнэ хүүтэйгээр худалдаж зээл авч болох ажээ. Гэхдээ тодорхой шалгуур нөхцөл байдаг ажээ. Манайд ямар шалгуур оновчтой байхыг тодруулж зааж өгмөөр байгаа юм.

Хоёрдахь нь овернайт зээллэг. Банкууд өмнө тохиролцсон барьцаа (Монголын хувьд юу байх вэ, ялангуяа Засгийн газраас бондын гаргалт, олдоц хязгаартай нөхцөлд)хөрөнгийн хэмжээнд овернайт зээлийг аль ч үедээ төв банкнаас тэдний зарласан ханшаар авч болно. **Гуравдахь хэрэгсэл нь хадгаламж** байрлуулах механизм юм. Арилжааны банкууд өөрийн татан төвлөрүүлсэн хадгаламжийн зохих хэсгийг төв банкуудад байршуулж, тодорхой хүүний урамшуулал авдаг байна. Үүнийг сайн дурын болон албадлагын үндсэн дээр хийж болно гэж ойлгогдож байна. Тухайлбал, Заавал байлгах нөөц.

Заавал байлгах нөөц: Арилжааны банкууд өөрсдийн төвлөрүүлсэн хадгаламжийн тодорхой хэсгийг Төв банкин дахь харилцахдаа байршуулах үүрэгтэй байна. Хувь хэмжээ нь тухайн үеийн нөхцөл байдлаас хамаардаг. Ялангуяа эдийн засаг сайн байх үед заавал байлгах нөөцийг нэмэгдүүлж, хүндрэл ирэх үед ашиглах нөөцийг бүрдүүлэх нь гол зорилт болно. Орчин цагийн түүхэнд тухайлбал, 1997-1998 оны Азийн хямралаас сургамж авч, Азийн зарим орнууд заавал байлгах нөөцийн хэмжээнд ихээхэн анхаарал тавьдаг болсон бөгөөд 2007-2009 оны хямралаас өмнө Өмнөд Солонгос зэрэг орнууд ихээхэн нөөцийг Төв банкиныхаа мэдэлд үндэсний болон валютын хангалттай нөөц бүрдүүлж чадсан байсан.

Мөнгөний бодлогын шилжилтийн/нөлөөллийн/ механизм нь дараах дэд элементүүдээс бүрддэг байна. Үүнд:

- Төв банкны гол зорилтын хэмжигдэхүүн болох богино хугацаат зээлийн хүүний түвшин нь бүх төрлийн зээлийн хүү, төлбөрийн хуваарь, санхүүгийн хэрэгслүүдийн хөдөлгөөний нийт матриц график үүсгэхэд нөлөө үзүүлнэ.
- Санхүүгийн системээс бодит эдийн засагт нөлөөлнө. Нөгөө талаас бодит эдийн засгаас санхүүгийн системд бас нөлөөлөнө. Жишээлбэл: Эдийн засгийг хөрөнгө мөнгөөр хангахад санхүүгийн системээс үүсэлтэй хүчин зүйлс нөлөөлдгийн адил аж ахуйн нэгжүүд зээл, хүүгээ төлж чадахгүй бол банк, санхүүгийн байгууллагуудын санхүүг хүндрүүлж, тэдний тайлан балансын байдлыг сулруулах нөлөөтэй. Бодит эдийн засгийг хөтлөгчид бол өрх, аж ахуйн нэгж, засгийн газраас эхлүүлээд олон хүчин зүйлс байж болно гэдэг байна.
- Бодит эдийн засгаас үнийн тогтвортой байдлыг хангах гэхчлэн мөнгөний бодлогын суурь зорилтыг хангахад үзүүлэх нөлөөлөл бий. Эдийн засаг хэвийн байваас төв банкны бодлогын хүү/богино хугацаат хүү/ нь санхүүгийн салбар дахь нийт зээлийн хүү, зээлийн хэмжээнд үзүүлэх нөлөө нь тогтвортой, урьдчилан төсөөлөх боломжтой, аливаа төрлийн тооны хязгаарлалт шаардлагагүй болж, зээлдэгч хүссэн үедээ зах зээлийн, хэвийн хүүтэй зээл олгох банк, хөрөнгө оруулагчийг олох боломжтой байдаг байна.

Аливаа төв банкны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, төлбөрийн тогтолцоог хөгжүүлэх, статистик мэдээлэл гаргах, эрх зүйн зохицуулалт хийх, санхүүгийн эрсдэлийн менежмент зэрэг үүрэг функцийг нь судалгаанд авч үзээгүй гэдгийг тэмдэглэе.

Хоёр. Мөнгөний бодлогын хэрэгжилтийн эрх зүйн үндэс

Мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар манай хууль эрх зүйд хэрхэн туссаныг үзүүлбэл:

Монгол Улсын төв банк(Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлд Монголбанкны үндсэн зорилт

1. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.
2. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү заалтаас үзэхэд Монголбанк шаардлагатай үед эдийн засгийг мөнгөн хөрөнгөөр хангах тухай заагаагүй нь хоёр талтай ойлгогдож байна. Сайн тал нь улстөрчдийн зүгээс мөнгө гаргахыг шаардахгүй, сөрөг тал нь Монголбанк мөнгө гаргах эсэх нь бүрхэг, элдэв шалтгаанаар Монголбанкинд хариуцлага хүлээлгэх магадлал харагдаж байна.

Монголбанкны тухай хуулийн 5 дугаар зүйлд үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

1.Монголбанк тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан төгрөгийн тогтвортой байлгах зорилтыг хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийн үйл ажиллагааг эрхэлнэ:

- 1/мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах;
- 2/мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
- 3/Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;
- 4/банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- 5/үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих;
- 6/гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;
- 7/банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- 8/макро зохистой бодлого хэрэгжүүлэх.

Монгол банкны тухай хуулийн хоёр дугаар бүлэгт мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх тухай нарийвчлан заажээ.

Тухайлбал, хуулийн 10 дугаар зүйл. Мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх

1. Монголбанк төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.
2. Монголбанк дараагийн жилд баримтлах төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн барих бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгасан байна:

1/ тайлант оны төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийн явц, санхүүгийн зах зээлийн байдал, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг тайлбарласан дүгнэлт;

11 дүгээр зүйл. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл

1. Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ дараахь арга, хэрэгслийг ашиглаж болно:

- 1/ банкны заавал байлгах нөөц, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох;
- 2/ банкинд зээл олгох, санхүүгийн хэрэгсэл ашиглах;
- 3/ хүүгийн нэгдсэн бодлого явуулах;
- 4/ нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах;
- 5/ банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх.

Дээрх хэрэгслийг хуульд хэрхэн дэлгэрүүлснийг үзүүлбэл:

12 дугаар зүйл. Банкны заавал байлгах нөөц

1. Монголбанк иргэн, хуулийн этгээдийн банкин дахь харилцах данс, хадгаламжийн үлдэгдэл болон Монголбанкнаас тогтоосон банкны бусад пассивын дүнгийн тодорхой хувийг бэлэн нөөцийн байдлаар заавал байлгахыг банкнаас шаардана.

2. Монголбанк банкны заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг **гучин хувиас** дээшгүй байхаар тогтоох бөгөөд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хугацаа, төрлөөс хамааруулан ялгаатай тогтоож болно.

3. Банкны бэлэн нөөц нь тухайн банкны кассад байгаа бэлэн мөнгө ба Монголбанкн дахь харилцах дансны үлдэгдлийн хэлбэрээр байж болно.

4. Монголбанк банкны заавал байлгах нөөцийг хангасан хэсэгт ногдох бэлэн нөөцөд хүү төлж болно.

5. Монголбанк заавал байлгах нөөцийг дутагдуулсан банкинд торгууль ногдуулна. Торгуулийн дээд хязгаар нь тухайн үед Монголбанкнаас банкинд олгох хамгийн өндөр хүүтэй зээлийн хүү дээр таван нэгж хувийг нэмсэнээс илүүгүй байна.

6. Банкны заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журмыг Монголбанк тогтооно.

13 дугаар зүйл. Банкннд зээл олгох, санхүүгийн хэрэгсэл ашиглах

1. Монголбанк мөнгөний зах дахь мөнгөн хөрөнгийн нөөцийн илүүдэл, дутагдлыг зохицуулах зорилгоор банкинд зээл олгож, санхүүгийн хэрэгсэл ашиглаж болно.

2. Банкннд олгох зээлийн нөхцөл, санхүүгийн хэрэгсэл ашиглах журмыг Монголбанк тогтооно.

14 дүгээр зүйл. Хүүгийн нэгдсэн бодлого явуулах

Монголбанк нь өөрийн зээл, үнэт цаасны хүү болон хямдруулалтын хувиар дамжуулан банкны хүүгийн нэгдсэн бодлого явуулна.

15 дугаар зүйл.Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах

1.Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ үнэт цаас гаргах, түүнийг худалдан авах, худалдах, Засгийн газрын үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Монголбанкнаас зөвшөөрсөн бусад үнэт цаасыг мөнгөний зах дээр худалдах, худалдаж авах замаар нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй.

16 дугаар зүйл. Банкнаас олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийх

Монголбанк хуулийн дээр дурдсан 11 дүгээр зүйлийн 1-ээс 4-т заасан мөнгөний бодлогын хэрэгслийг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд банкнаас иргэн, хуулийн этгээдэд олгох зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж болно.

21 дүгээр зүйл.Макро зохистой бодлого хэрэгжүүлэх

1.Монголбанк мөнгөний бодлогын хэрэгжилт болон банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор макро зохистой бодлогыг боловсруулж, энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэгслийг ашиглан хэрэгжүүлнэ

Монголбанкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг нарийвчлан авч үзэж, Монголбанкнаас тайлбар авах хэрэгтэй байгаа юм.

2. Монголбанк дараахь үйл ажиллагаа явуулах нь Монголбанкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн зүйлийн 1 дэх хэсэгт заасан хориглолтууд дараахид хамаарахгүй ажээ. Үүнд:

1/ үүрэг гүйцэтгэх хугацаа нэг жилээс дээш хэтэрсэн тохиолдолд авлага барагдуулах зорилгоор боломжтой хугацааны дотор худалдах нөхцөлтэйгээр энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2 (2/ ашиг олох зорилгоор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө худалдан авах, худалдах); ,4- (4/ хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах, үнэт цаас худалдан авах, худалдах)-т заасан хөрөнгө, үнэт цаасыг худалдан авах;

2/ нийт дүнгээрээ өөрийн хөрөнгийн гурван хувиас хэтрүүлэхгүйгээр дангаараа хадгаламжийн даатгал, экспортын санхүүжилт, төлбөр харилцан суутгах үйл ажиллагаа, автоматжуулалт, банкны мэдээлэл боловсруулалт эрхэлдэг болон мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой хуулийн этгээдийн хувьцааг эзэмших;

Монголбанкны тухай хуульд 2018 онд орсон өөрчлөлттөөр Мөнгөний бодлогын хороо, Хяналт шалгалтын хороог байгуулжээ. Эдгээр хороодын ажил үүргийн хуваарийг үзүүлбэл:

Мөнгөний бодлогын хороо дараахь асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ:

- 1/төрийн мөнгөний бодлогын төсөл;
- 2/мөнгөний бодлогын хэрэгслийн хүүг тогтоох;
- 3/банкны заавал байлгах нөөцийн хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хувь, хэмжээг тогтоох.

Банкны хяналт шалгалтын хороо

1.Банкны хяналт шалгалтын хороо нь банкинд хяналт тавих Монголбанкны бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараахь асуудлыг хэлэлцэж, зөвлөмж гаргана:

1/банкны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, банкны үйл ажиллагааг хуульд заасны дагуу зохицуулах, банкинд авах албадлагын арга хэмжээтэй холбоотой дүрэм, журам, заавар, аргачлал, бусад шийдвэрийн төсөл;

2/банкинд хийсэн хяналт шалгалтын тайлан;

3/банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хуульд заасны дагуу банк, Хадгаламжийн даатгалын корпорацид зээл олгох санал.

2.Банкны хяналт шалгалтын хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

Дээр дурдсан хоёр хорооны бүрэн эрх нэлээд зөрүүтэй харагдаж байна. Мөнгөний бодлогын хороо хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргадаг бол Банкны хяналт шалгалтын хороо зөвлөмж гаргах ажээ. Өөр нэг анхаарал татаж буй зүйл бол Мөнгөний бодлогын хорооны гишүүд нь 7 бөгөөд Монголбанкны 3 ерөнхийлөгч, тэргүүн дэд ба дэд ерөнхийлөгчөөс гадна 4 бие даасан гишүүнтэй буюу гаднаас сонгогдсон хүмүүс давуу эрх эдлэх боломж харагдаж байна. Мөн эдгээр бие даасан 4 гишүүн нь их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас томилогдох макро эдийн засаг санхүүгийн мэргэжлийн эрдэмтэд байх ажээ. Төрийн мөнгө, санхүү, эдийн засгийн бодлого, стратегийн асуудал хариуцсан засгийн газрын төлөөлөл Мөнгөний бодлогын хорооны бүрэлдэхүүнд байхгүй байгаа нь онцлогтой байна.

Банкны хяналт шалгалтын хорооны бүрэлдэхүүнийг Монголбанкны Ерөнхийлөгч тогтоох ажээ. Тус хороо арилжааны банкуудын үйл хэрэг болон тэдэнд зээл олгохтой холбогдсон амин чухал асуудлаар санал гаргах бөгөөд харин эцсийн шийдвэрийг Монголбанкны удирдлага гаргахаар байна. Банкны Хяналтын хорооны үйл ажиллагааны үр дүн болон бие даасан байдал нь хязгаарлагдмал, урьдын адил Монголбанк арилжааны банкуудыг хэрхэн удирдаж буйд хөндлөнгийн хяналт, дүгнэлт тавих тогтолцоо бүрдээгүй байна гэжээ үзэж байна.

Монголбанкны тухай хуулийн УИХ-тай харилцах харилцааг зохицуулсан 30 дугаар зүйлийн 3-д:”Монголбанк санхүүгийн тайлангаа аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна” гэж заажээ. Энэхүү заалтад ач холбогдол өгч, Хяналтын Зөвлөл санал, зөвлөмжөө бодитой, үндэслэл сайтай гаргахын зэрэгцээ Монголбанкны зүгээс бас анхаарал тавьж буй эсэхийг тодруулж байх нь чухал юм. Монголбанкны санхүүгийн тайлан нь банкны бүх үйл ажиллагааны эцсийн үр дүнгийн цог үзүүлэлт мөн эсэх талаар илүү нарийвчлан үзүүштэй харагдаж байна. Ялангуяа аливаа төв банкны тайлангийн ямар үзүүлэлтүүд нь хамгийн чухал болохыг тогтоож, мөрдөх нь чухал юм. Монголбанкны зарим мэргэжилтэн төв банкны ашиг, төлбөрийн чадвар зэрэг нь төдийлэн чухал биш юм шиг ярих нь үндэслэлтэй эсэх, өөр ямар үзүүлэлтүүд хамгийн чухал болох талаар нэгдсэн ойлголтод хүрэх хэрэгтэй байгаа юм.

Энэхүү судалгааны гол сэдэв болох мөнгөний бодлогын хэрэгжилтийн асуудал руу орёо.

Монголбанкны тухай хуулийн Засгийн газартай харьцах 31 дүгээр зүйлд “Монголбанк энэ хуулийн 15 зүйл (1.Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ үнэт цаас гаргах, түүнийг худалдан авах, худалдах, Засгийн газрын үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Монголбанкнаас зөвшөөрсөн бусад үнэт цаасыг мөнгөний зах дээр худалдах, худалдаж авах замаар нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй), 18 дугаар зүйл (1.Монголбанк улсын төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг нөхөхөд зориулж тухайн санхүүгийн жил дуусахаас өмнө төлөгдсөн байх нөхцөлтэйгөөр Засгийн газарт зээл олгох буюу Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасыг худалдан авч болно. 2. Тухайн санхүүгийн жилийн түр хугацааны зээлийн үлдэгдлийн нийт хэмжээ нь дотоодоос төсөвт сүүлийн гурван жилд орсон орлогын дунджийн арван хувиас хэтрэхгүй байна. Дотоодоос төсөвт орох орлогод Засгийн газар өөрийн активыг зарж борлуулсны орлого болон дотоодын зээллэг, үнэт цаас гаргаснаар олох орлогыг хамааруулахгүй.)-д зааснаас бусад тохиолдолд Засгийн газарт шууд болон шууд бусаар зээл олгох, Засгийн газрын урт, богино хугацаат үнэт цаасыг анхдагч, эсхүл хоёрдогч захаас болон шууд худалдан авахыг хориглоно.

Монголбанкнаас дээрх заалтын хүрээнд засгийн газарт зээл олголттой холбогдсон асуудлыг нарийвчлан судалж, гадаад орнуудын төв банкуудын хэрэгжүүлдэг мөнгөний зөөлөн бодлого, бодлогын болон хөтөлбөрт зээл зэрэг эдийн засгийг дэмжих дунд, урт хугацаат зээллэгийн асуудлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай болов уу. Монголбанк өөрийн санхүүгийн байдалд хохирол учруулахгүйгээр зээл олгох, зах зээл дэх мөнгөний хангамжийг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан судлах болно.

Гурав. Мөнгөний бодлогын хэрэгжилт

Мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар дараах шийдвэрүүд гарчээ.

Мөнгөний бодлогын шийдвэр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгалах, Банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 60 хувиар шинэчлэн тогтоов. Мөнгөний бодлогын хороо инфляцид нөлөөлж буй эрэлт, нийлүүлэлтийн болон гадаад хүчин зүйлс, тэдгээрийн цаашдын төлөв, бизнесийн идэвхжилийг харгалзан бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалахаар шийдвэрлэсэн болно гэсэн тайлбар хийжээ. .

Мөнгөний бодлого эдийн засгийн идэвхжилд эрэлт талаас нь тодорхой хугацааны хоцрогдолтойгоор нөлөөлдөг тул тогтмол шинж чанар багатай, түр зуурын нийлүүлэлтийн шинж чанартай бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хариу үйлдэл үзүүлэхгүй байх зарчмыг Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгажээ. Монголын эдийн засагт гадаад болон дотоод орчноос хамаарсан эрэлт болон нийлүүлэлтийн гаралтай шокууд тогтмол бий болж, зарим саруудад үнийг савлуулах нөлөө үзүүлдэг боловч мөнгөний бодлого дунд хугацаанд инфляцийн хэлбэлзлийг тогтворжуулж, зорилтот түвшинд нь байлгахыг зорьж байна.

Тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг бууруулж, 60 хувиар тогтоох шийдвэр нь сүүлийн жилүүдэд хурдацтай өсч, өндөр түвшинд хүрсэн хэрэглээний зээл, иргэдийн өрийн дарамтыг цалингийн өсөлттэй уялдуулан аажмаар бууруулах зорилготой байв.

Мөнгөний бодлогын хорооны хурлын шийдвэрийг тус өдрийн хэвлэлийн бага хурлаар танилцуулж, мөнгөний бодлогын мэдэгдлийг Монголбанкны цахим хуудсанд байршуулсны зэрэгцээ хурлын хураангуй тэмдэглэлийг хурлаас хоёр долоо хоногийн дараа мөн цахим хуудсанд байршуулан Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллалаа.

Төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийг тоон илэрхийлэл буюу Монголбанкны 2019 оны 9 дүгээр сарын 30-ны санхүүгийн тайлангаас үзэхэд балансын эх үүсвэр талдаа буюу Монголбанкнаас хүү төлдөг Төв банкны үнэт цаас 4.56 их наяд, банкуудын хөрөнгө 4.50 их наяд, гадаад өр 4.70 их наяд байгаа бөгөөд эдгээр болон нийт өрөнд нийтдээ 672,3 тэрбум хүү төлж байна. Тэгвэл эдгээр эх үүсвэрт төлж буй хүүгээ нөхөн олох хэмжээний орлогыг олох учиртай. Актив талдаа эдгээр хөрөнгийг хэрхэн зээлдүүлэн байрлуулж, хүү төлүүлж буй нь төдийлэн харагдахгүй байна. Нийт дүнгээр нь харахад 232,55 тэрбум төгрөгийн хүү олжээ. Ийм их зөрүүтэй (хүүгийн зарлага 672,3 тэрбум, орлого нь 232,55 тэрбум төг)байх нь хэвийн үйл ажиллагаа мөн үү? гэдэг асуудалд Монголбанкны экспертүүдээс хариу хүсэж байгаа юм.

Дээрх алдагдлыг үнэ, ханшийн уналтаас үүссэн орлогоор нөхөж буй ч гэсэн эдгээр орлого нь цаг үеийн шинжтэй бөгөөд хүүгийн зөрүү тогтмол, байнга гараад байх шинжтэй байна. Энэ нь эрсдэл үүсгэж буй бөгөөд алдагдал авчирч болох мөнгөний бодлогын хэрэгслүүдийг цаашид хэрхэн удирдах вэ гэдэг асуудал байна. Хэрэв алдагдал гаргах замаар мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангана гэвэл гадаад улс орнуудын туршлагын дагуу төсөв хариуцсан байгууллагатай зөвшилцөж, автоматаар алдагдалд ногдох эх үүсвэрийг төрөөр нөхүүлдэг байх уу гэсэн асуулт гарна аа. Зөвлөлдөж санал дүгнэлт гаргах хэрэгтэй болно.

Санал дүгнэлт.

1. Мөнгөний бодлогын хэрэгжилтийн арга хэрэгслүүд манай улсын төв банкны хууль болон бусад хууль тогтоомжид үндсэндээ бүрэн суусан байна.

2. Хэрэгжүүлж буй арга хэрэгслүүд өнөөгийн шаардлагыг хангаж байна гэж үзлээ. Гэлээ гэхдээ эдийн засгийг мөнгөн хөрөнгөөр хангах, зээл олгох, хүүгийн нэгдсэн бодлого явуулах, бодлогын хүү, арилжааны банкуудын хүүгийн хоорондын харьцаа, мөнгө хүүлэх ажиллагааг зохицуулах зэрэг мөнгөний бодлогын хэрэгжилтийн зарим хэрэгсэл арга ажиллагаа нь хязгаарлагдмал мэт ойлголт төрлөө. Дээр дурдсан зарим тодруулах зүйлс болон энэхүү дүгнэлтийн талаар санал бодлоо нээлттэй хэлэлцэж нэгдсэн ойлголтод хүрэхийг хүсэж байна.

3. Төгрөгийн ханш, инфляцийг тогтвортой бөгөөд ончтой түвшинд байлгах гол арга нь үнэ ханшид нөлөөлж болох хязгаарлалт, захиргааны арга хэмжээ авахгүй байхыг сэрэмжлүүлэх нь Монголбанкны чухал үүрэг биз ээ. Хүү аливаа барааны адил зээл-мөнгөний л үнэ. Энэ үнийн хувьд нэг үнийн бодлогыг барихгүй бол зах зээлд заавал гажуудал үүснэ гэж бодож байна. Жишээ нь ЖДҮ-гийн зээл. Аливаа бага хүүтэй зээлийг “арын”хаалгатай нь авч, хадгаламж зээлийн хоршоо эсвэл ламбардаар дамжуулан сарын 3-4 хувь буюу жилийн 40-өөс 50 хувийн хүүтэй зээл олгож мөнгө хүүлнэ. Үүнийг болиулах арга механизмаа олохгүй бол хүү бууруулах боломж мөд гарахгүй бололтой. Сүүлийн үед инфляци өдөөдөг гол бүтээгдэхүүн мах болчихоод байна. Үүнд бас л нэг үнийн бодлого дутагдаад байгаа юм.

Эхний ээлжинд мал аж ахуйн түүхий эдийн борлуулалт, экспортод аливаа хязгаарлалт хэрэггүй. Гэхдээ стратегийн бараа болох мах, улаан буудай, нефть бүтээгдэхүүний нөөц, хангамжийн мэдээллийг 2 долоо хоног тутам авч, дүгнэлт хийж байх нь чухал юм. Эдгээр бүтээгдэхүүний аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтийг ямагт анхаарч байх, Засгийн газарт тодорхой арга хэмжээ авахыг зөвлөж байх. Нөөц бүрдүүлэхэд санхүүгийн эх үүсвэрийг гаргаж байх хэрэгтэй.

4. Мөнгөний бодлогын хэрэгжилтийн үр дүнд аливаа хууль бус үйлдэл нөлөөтэй. Жишээ нь төгрөгийн ханшийг хиймлээр дээш доош болгох замаар мөнгө угаах ажиллагаа явагдах эсэхээс урьдчилан сэргийлэх, үүний тулд газар дээрх зах зээлийн гүнзгий судалгаа, тагнуулын тандалт, мөрдөлтийг тогтмол хийж байвал зохих биз ээ.

Алтыг Монголбанк зах зээлийн үнээр худалдан аваад л байдаг. Гэтэл зарим алт олборлогчид, тэдний эзэд татвар төлөхгүй, ажилчиддаа өөдтэй мөнгө өгөхгүй өөрсдөө авч, үрэлгэн загнаж, жип унан, гангарч, шалиглах эсвэл захаас доллар цуглуулаад гадаадад аялж, жаргал цэнгээн хөөгөөд байвал төгрөгийн ханш улам унана. Ийм эсэхэд бас л судалгаа хэрэгтэй.

5. Мөнгөний бодлогын хэрэгжилтийн үр дүн нь “улс орны нийт нөөц, хадгаламжийг найдвартай байлгах, бизнес хэвийн, түүний дотор эдийн засгийн хүндрэлийн үед ашиглах боломжтой нөөцийг санхүүгийн системд байлгах, хүмүүс үнэ ханшийн талаар амар амгалан итгэлтэй байгаагаар хэмжигдэж болох”ыг судалгаа харуулж байна. Манайхан чадлынхаа хэмжээнд “ иймэрхүү үр дүнгийн төлөө ажиллаж байна” гэсэн дүгнэлттэй байна.

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.ДАВААСАМБУУ

ⁱ Үйлдвэржсэн орнуудын төв банкууд өдгөө “хямдруулсан” зээл эх үүсвэрийг жинхэнэ утгаар хэрэглэхгүй болсон бөгөөд нэр томъёо санхүүгийн хэллэг болон үлджээ. Хямдралтай хүүтэй эх үүсвэрийг өрнөдийн орнууд өнгөрсөн зууны дунд үе хүртэл ихээхэн хэрэглэж байжээ.